



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 1 дүгээр сарын 18-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 18 ЖУРАМ БАТЛАХ, ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5, 13.12, Улсын Их Хурлын 2016 оны 63 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2017 оны 361-р тогтоолоор өөрчлөлт орсон/

2. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 1.1 дэх заалтын “13.1.2” гэсний дараа “13.1.5” гэж нэмсүгэй.

3. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгох ажлыг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 70 дугаар тогтоолыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын сайд

Н.НОМТОЙБАЯР



Засгийн газрын 2017 оны 18 дугаар
тогтоолын хавсралт

ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж (цаашид “хүүхдийн мөнгө” гэх) олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд (цаашид “хүүхэд” гэх), эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий Монгол Улсын иргэнд олгоно.
- 1.3. Хүүхэд болон хүүхдийг төлөөлөн хүүхдийн мөнгө авах эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) үйлчлүүлэх банкнийг өөрөө сонгоно. Тухайн хүүхдэд хүүхдийн мөнгө олгох зөвхөн нэг банкнийг сонгож, уг банкинд өөр эзэмшигч ашиглаж байгаагүй зөвхөн нэг данс нээлгэнэ.

Хоёр. Хүүхдийн мөнгө авах иргэний хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх

- 2.1. Хүүхдийн эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд), эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрийн биеэр хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргах эрхтэй.
- 2.2. Энэхүү журмын 2.1-д заасан иргэн сонгосон банкны салбарт биеэр очиж хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргана. Хүсэлт гаргахдаа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж банкны ажилтанд өгнө:
 - 2.2.1. хүүхдийг төлөөлөн хүүхдийн мөнгө авах эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд)-ийн иргэний үнэмлэх;
 - 2.2.2. хүүхдийн төрсний гэрчилгээ, хэрэв хүүхэд 16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх;
 - 2.2.3. Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч шаардлагатай тохиолдолд мөн хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилсон тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж.

2.3. Банкны ажилтан нь энэхүү журмын 2.2.1-2.2.3-т заасан баримт бичгийг хүлээн авч өргөдлийн маягтыг цахим хэлбэрээр бөглөн хүсэлт гаргасан иргэнээр гарын үсэг зуруулж баталгаажуулан, хүсэлтийг хүлээн авсан хугацааг өргөдөлд тодорхой бичнэ. Өргөдлийн маягтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

2.4. Энэхүү журмын 2.3-т заасан өргөдлийн маягт дахь мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн банк бүрэн хариуцна.

2.5. Энэхүү журмын 2.1-д заасан иргэн хүүхдийн мөнгө авах дансыг хүүхэд тус бүрээр нээлгэх бөгөөд эдгээр дансыг нэгтгэн нэг дансаар хүүхдийн мөнгө авах хүсэлтэй бол тухайн банк нь уг иргэний дансанд холболт хийнэ.

2.6. Хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан иргэний мэдээллийг банкны салбарын ажилтан тухайн банкинд, банк нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.7. Банк мэдээллийн санд шинээр нэмэгдсэн, дансны мэдээлэлд нь өөрчлөлт орсон хүүхдийн нэрсийн жагсаалтыг сар бүрийн 10-ны өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

2.8. Банкнаас ирүүлсэн хүүхдийн мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

2.9. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шинээр төрсөн, нас барсан, харьяатаас гарсан зэрэг 0-18 хүртэлх насны хүүхдийн регистрийн дугаар, овог, нэр, оршин суугаа хаягийн мэдээллийг сар бүрийн 5-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.10. Энэхүү журмын 2.9-т заасан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүйгээс учирсан хохирлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

2.11. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэхүү журмын 2.7-д заасан мэдээллийг энэхүү журмын 2.9-т заасан мэдээлэлтэй тулган шалгаж баталгаажуулан хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэрсийн жагсаалтыг тухайн сарын 15-ны дотор Монголбанк болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн газар (цаашид “Төрийн сангийн газар” гэх)-т цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

2.12. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэрсийн жагсаалтын мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг Монголбанк хариуцна.

2.13. Төрийн сангийн газар нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн холбогдох санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн халамжийн санд байршуулж зарцуулах эрхийг нээнэ. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн халамжийн сангийн данснаас Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд байршуулна.

2.14. Төрийн сангийн газраас хүүхдийн мөнгөнд олгосон санхүүжилт тухайн сард банкуудад шилжүүлэх хөрөнгөөс илүү гарсан тохиолдолд үлдэгдэл мөнгийг Төрийн сангийн газрын дансанд буцаана.

2.15. Төрийн сангийн газраас хүүхдийн мөнгөнд олгосон санхүүжилт тухайн сард банкуудад шилжүүлэх хөрөнгөөс бага байгаа тохиолдолд бүрэн санхүүжүүлэх үүргийг Төрийн сангийн газар хүлээнэ.

2.16. Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд энэхүү журмын 2.13-т заасан хөрөнгө бүрэн байршсан тохиолдолд хүүхдийн мөнгө олгох нэрсийн жагсаалтыг үндэслэн Монголбанк банкууд дахь тухайн хүүхэд бүрийн дансанд мөнгийг сар бүрийн 20-ны дотор бүрэн байршуулна. Хүүхдийн мөнгөний санхүүжилт бүрэн хийгдээгүй тохиолдолд Монголбанк хүүхдийн мөнгийг банкинд шилжүүлэхгүй.

2.17. Тухайн иргэн хүүхдийн мөнгийг сар бүрийн 20-ны өдрөөс хойш өөрийн сонгосон банкнаас авна.

2.18. Монголбанк хүүхдийн мөнгө олгож байгаа банктай сар бүр тооцоо нийлж, мөнгө олгосон нэрсийн жагсаалтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүрийн 25-ны дотор цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

2.19. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн мөнгөний олголт, зарцуулсан хөрөнгийн мэдээг дараа сарын 4-ний дотор санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

2.20. Энэхүү журмын 2.2-т заасны дагуу иргэн хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан боловч хүүхдийн мөнгө тухайн ондоо багтан дансанд нь ороогүй тохиолдолд дараа оны төсвөөс нөхөн олгоно.

2.21. Хүүхдийн мөнгө авахаар нэгээс дээш банкинд данс нээлгэх хүсэлт гаргасан нөхцөлд иргэний хамгийн сүүлд хүсэлт гаргасан банкны дансаар хүүхдийн мөнгийг олгоно.

2.22. Сум, хорооны нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан иргэнд бүрдүүлэх баримт бичиг, тухайн өрх нь Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн эсэх, өрхийн амьжиргааны түвшингийн онооны талаар үнэн зөв мэдээлэл өгч ажиллана.

Гурав. Хүүхдийн мөнгө олгох

3.1. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрх, иргэний хүүхдийн мөнгийг банкинд хүсэлт гаргасан сараас тооцон сар бүр олгоно. /Энэ заалтыг 2017 оны 361-р тогтоолын дагуу 2017 онд дагаж мөрдөхгүй байхаар тогтсон/

3.2. Иргэн хүүхдийн мөнгө авч байгаа банкныг солих хүсэлтэй бол сонгосон банкны ажилтанд хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргана.

3.3. Иргэн засаг захиргааны нэг нэгжээс өөр нэгжид бүрмөсөн шилжин суурьшсан тохиолдолд шилжин очсон нутаг дэвсгэрийн банкны салбараас хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн авна. Хэрэв тухайн банкны салбар нь шилжин очсон нутаг дэвсгэрт байхгүй бол энэхүү журмын 3.2-т заасны дагуу хүсэлтээ гаргана.

3.4. Бүтэн өнчин, эцэг эхгүй болон асран хамгаалагч томилогдоогүй зэрэг шалтгаанаар асрамжийн газарт асруулж байгаа хүүхдийн мөнгийг асрамжийн газар нь тухайн хүүхдийн нэр дээр хадгаламжийн данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн асрамжийн газрын байрлаж байгаа аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг 16 нас хүрч иргэний үнэмлэх авсны дараа өөрт нь хүлээлгэн өгнө. Хэрэв хүүхэд нас барсан тохиолдолд түүний хадгаламжийн дэвтрийг өв залгамжлагчид нь хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэн өгнө.

3.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагад ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүүхдийн мөнгийг тухайн хүүхдийн нэр дээр хадгаламжийн данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн хорих ангийн байрлаж байгаа аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг суллагдсаны дараа өөрт нь хүлээлгэн өгнө. Хэрэв хүүхэд 16 насанд хүрээгүй тохиолдолд эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд)-д, нас барсан тохиолдолд өв залгамжлагчид нь хууль тогтоомжид заасны дагуу дэвтрийг хүлээлгэн өгнө.

3.6. Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэний хүүхдийн мөнгийг төлөөлөн авах иргэний өргөдөл, хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын итгэмжлэл, тодорхойлолтыг үндэслэн итгэмжлэгдсэн этгээдэд нь олгоно.

3.7. Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж хоёрдмол харьяалалтай болсон иргэний хүүхдэд хүүхдийн мөнгө олгохгүй.

3.8. Хүүхэд шинээр төрсөн, үрчлэгдсэн, нас барсан зэргээр тухайн гэр бүлд амьдарч байгаа хүүхдийн тоо өөрчлөгдсөн тохиолдолд эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) нь энэ тухай сонгосон банк болон тухайн орон нутгийн улсын бүртгэлийн байгууллага, ажилтанд бичгээр мэдэгдэнэ.

3.9. Тухайн өрхийн амжиргааны түвшний оноо нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан босго шугамаас доогуур байгаа тохиолдолд хүүхдэд нийгмийн халамжийн сангаас сар бүр хүүхдийн мөнгийг бэлэн мөнгөөр олгох ажлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

3.10. Тухайн өрхийн амьжиргааны түвшний оноо нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан босго шугамаас дээш байгаа тохиолдолд хүүхдийн мөнгийг бэлэн бусаар олгох хүүхдийн нэрсийн жагсаалтыг сар болон жилээр гаргаж, цахим хэлбэрээр төсөв, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкинд хүргүүлнэ. Бэлэн бусаар авах өрхийн хүүхдийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

Дөрөв. Хүүхдийн мөнгө олгохыг зогсоох

4.1. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг зогсоох шийдвэр гаргана:

4.1.1. хүүхэд 18 нас хүрсэн;

4.1.2. хүүхэд нас барсан;

4.1.3. Монгол Улсын харьяатаас гарсан.

4.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг түр зогсоох шийдвэр гаргана:

4.2.1. хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэл өгөх, хүүхдийн мөнгө авахаар нэгээс дээш банкинд санаатайгаар давхар данс нээлгэх зэргээр хүүхдийн мөнгө авсан нь тогтоогдсон;

4.2.2. регистрийн дугаар давхардах зэрэг өөр бусад шалтгаанаар хүүхдийн мөнгө илүү олгогдсон;

4.2.3. тухайн өрхийн ам бүлийн тоо гурав болон түүнээс дээш гишүүнээр өөрчлөгдсөн;

4.2.4. хүүхдийн мөнгө авч байгаа өрх нь сум, дүүрэг, аймаг хооронд шилжилт хөдөлгөөн хийсэн.

4.3. Энэхүү журмын 4.2.1-д заасны дагуу түр зогсоосон хүүхдийн мөнгийг нөхөн олгохгүй.

4.4. Хүүхдийн мөнгө олгохтой холбоотойгоор өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлэх ажлыг Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-ын дагуу зохион байгуулна.

4.5. Энэ журмын 4.2.3, 4.2.4-т заасны дагуу хүүхдийн мөнгөний олголтыг түр зогсоосон өрхийн мэдээллийг шинэчилсний дараа тухайн өрх нь хүүхдийн мөнгө авах нөхцөлийг

хангаж байгаа тохиолдолд үргэлжлүүлэн олгох бөгөөд түр зогсоосон хугацааны мөнгийг нөхөн олгоно.

Тав. Бусад

5.1. Иргэн энэхүү журмын 2.2-т заасан баримт бичгийг хуурамчаар үйлдэж хүүхдийн мөнгө авсан, эсхүл 3.8-д заасан өөрчлөлтийг мэдэгдээгүй, мөн журмын 4.2-т заасан нөхцөл үүссэн бол илүү авсан хүүхдийн мөнгийг эхний удаа нөхөн төлүүлж дараа сарынх нь хүүхдийн мөнгөнөөс суутгана.

5.2. Энэхүү журмын 5.1-д заасан суутгалыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдэгдлийг үндэслэн банк гүйцэтгэж, холбогдох дансанд төвлөрүүлэн энэ тухай мэдээллийг энэхүү журмын 2.7-д заасан жагсаалтын хамт хүргүүлнэ.

5.3. Нийгмийн халамжийн болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, банкны ажилтны гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----